



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 554

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 он, 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаарх санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулаагүй, хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан “босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг зөрчин 63.1 сая төгрөгийн бараа материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын холбогдох заалтыг зөрчин 74.0 сая төгрөгийн бараа материалыг харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд гэрээ байгуулан худалдан авсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 13 дугаар зүйлийн 13.7-д заасныг зөрчин 47.5 сая төгрөгийн ажил гүйлгээг бүрдэл дутуу баримтаар гүйцэтгэсэн зэрэг нийт 269.8 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчил дутагдал гаргасан, хяналт тавих чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн ажилтан, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хариуцлага тооцож шаардлагатай арга хэмжээ авах;

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг компанийн тухай хуульд заасан хугацаанд хуралдуулах, 2019 оны үлдэж буй хугацаанд компанийн орлого, зардлын төлөвлөгөө түүний хэрэгжилтийг хангуулах, өр төлбөр, авлагыг барагдуулах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2.3. Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 2013 онд үүссэн, 51.9 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал, 17.3 сая төгрөгийн маргаантай барилгын асуудлаар холбогдох шийдвэрийг гаргаж, эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

0001220

3. “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрахад дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, батлагдсан төлөвлөгөөнд гарсан өөрчлөлтийг эрх бүхий байгууллагаар тодотгож батлуулсны дараа хэрэгжүүлэх;

3.3. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг ханган ажиллах;

3.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлж, цаашид давтан гаргахгүй байх;

3.5. Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэхийг зогсоох;

3.6. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн  
557 дугаар тогтоолын хавсралт



“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-д хийсэн  
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг  
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчин зохион байгуулсан	2018 он, 2019-09-30	137.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 1, 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын холбогдох заалт	Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах ажлыг хууль, журамд нийцүүлэх
2	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан	2018 он, 2019-09-30	47.5	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 13 дугаар зүйлийн 13.7 дах хэсэг	Баримтыг нөхөн бүрдүүлэх, шалгуулах, баримтын бүрдлийг ханган ажиллах
3	Төсвийн өр төлбөрийг хугацаанд нь төлөөгүй /НӨАТ-ын өр/	2018 он, 2019-09-30	34.45	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь хэсэг	Төсвийн төлбөрийг хугацаанд нь төлөх, өр авлага үүсгэхгүй байх
4	2019 оны төлөвлөгөөт зардал хэтэрсэн	9/30/2019	20.6	2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 668 дугаар тогтоолоор баталсан зардлын төлөвлөгөө	Зардлын хэтрэлтэд дүн шинжилгээ хийж орлогын өсөлттэй уялдуулах
5	Кассаас бэлтгэн нийлүүлэгчид их хэмжээний мөнгө олгосон	2018 он, 2019-09-30	30.3	Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журам, НББ-ын бодлогын баримт бичиг	Кассаар их дүнтэй мөнгөн зарлагыг гаргахгүй байх
<b>НИЙТ ДҮН:</b>			<b>269.85</b>		